


AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН
ТАНИЛЦУУЛГА



ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛ

Шинжлэх ухаан, технологийн асар хурдацтай хөгжлийн явцад хүүхэд багачуудын мэдээлэл олж авах, сурах арга барил өөрчлөгдөж байгаа тул олон улсын боловсролын салбарын мэргэжилтнүүд, багш нар уламжлалт заах арга барилыг дэвшилтэт AR (Augmented Reality) технологитой хослуулж, интерактив тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан боловсрол олгож байна.

Энэхүү технологийн тусламжтайгаар орон зай, цаг хугацааны хувьд дүрслэн харуулах боломжгүй, хийсвэр зүйлс, тэдгээрийн хөдөлгөөн, урт хугацаанд явагддаг хувирал, өөрчлөлт зэргийг 3 хэмжээст хөдөлгөөнт дүрслэл, аудио, видео контенттой хослуулан хүүхэд багачуудад сургалтын агуулгыг маш сонирхолтой, хялбар аргаар ойлгуулах боломжтой юм.


Манай хамт олон бүтээлч, сонирхолтой, шинжлэх ухаанч агуулга бүхий эвлүүлдэг (PUZZLE) тоглоомоор дамжуулж бага насны хүүхдэд боловсрол олгох цогц контентыг хөгжүүлэн та бүхэнд танилцуулж байна. Интерактив эвлүүлдэг тоглоом нь хүүхдийн багаар ажиллах, сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг хөгжүүлэхээс гадна ой тогтоолт, анхаарал төвлөрөх, сэтгэн бодох, төсөөлөх, ажиглах, судлах, турших, өнгө дүрс ялгах зэрэг бүтээлч чадварыг хөгжүүлдгээрээ хамгийн том давуу талтай юм.

Та бүхэнд дэлхийн дэвшилтэт технологийг сургалтдаа нэвтрүүлж, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бидэнтэй хамтран ажиллахыг урьж байна.

Технологийн эрин зууны ирээдүй болсон хүүхэд багачуудынхаа мэдээлэл олж авах орц, сурах арга барилд тохирсон аргаар суурь мэдлэгийг хямд зардлаар, хялбар байдлаар олгох ухаалаг шийдлийг шингээсэн Augmented Reality технологитой хослуулан бүтээсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг та бүхэндээ хүргэж байна.



“ ХҮҮХЭД ТОГЛООМООРОО ДАМЖУУЛАН СУРАЛЦДАГ



Олон улсын судалгааны үр дүнгээс үзэхэд бодит мэт мэдрэмж төрүүлж, гүн сэтгэгдэл төрүүлэх шинж чанартай, ялган таних алгоритмд суурилсан AR (Augmented reality) технологийг боловсролын салбарт нэвтрүүлснээр хүүхдүүд агуулгыг хэзээ ч мартаггүйгээр бүрэн ойлгож, шинжлэх ухаан, технологи, мэдлэгт дурлах хүсэл тэмүүлэл бий болдог тул боловсролын чанар дөрөв дахин нэмэгддэг нь тогтоогджээ.

Технологид суурилсан тоглоомоор дамжуулан сонирхолтой, хялбар аргаар хүүхэд, багачуудын боловсрол, мэдлэгийг тэлэх “ARGUN KIDS” багцыг цэцэрлэгийн бүх ангийнханд зориулан бүтээлээ.

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ СУРГАЛТАД АШИГЛАСНААР

ДАВУУ ТАЛУУД:

- Сургалтын хэрэглэгдэхүүний дутагдлыг хямд зардлаар нөхнө.
- Нэг дүрсэд олон агуулгыг багтааж мэдлэг олгон, чадваржуулна.
- Интернэтгүй орчинд ажиллах боломжтой тул алслагдсан сум, суурин, хөдөө, хот, төрийн болон хувийн сургууль гэх ялгаварлалгүйгээр сурагч нэг бүрд дэлхийн дэвшилтэт технологийн тусламжтай мэдлэг олгоно.
- Багш нар гар утсандаа аппликейшнийг үнэ төлбөргүй татаж суулгаад сургалтын хэрэглэгдэхүүнийг шууд ашиглах боломжтой.
- AR технологийг ашиглан хичээллэх нь дэлгэцээр дамжуулан суралцахаас илүү бодит мэдрэмж төрүүлж, үр дүн өндөртэй байдаг.
- Сурагчид тухайн хичээл дээр харах, сонсох төдийхнөөр хязгаарлагдахгүй харж, туршиж, ажиглах боломж бүрдэнэ.
- Бага насны хүүхдэд ярианы болон тодорхой ойлголтын чадвар, дадал хөгжөөгүй байдаг тул тоглоомын аргаар сэтгэл хөдлөл, зан төлөвийг нь төлөвшүүлдэг.
- Хүүхдийг нас, сэтгэцийн онцлог, сонирхолд нь тохирсон тоглоомоор тоглуулснаар харааны болон гарын хөдөлгөөний эвсэлтэй болох, бүтээлч сэтгэхүй хөгжих, хэлбэр дүрс, өнгөний мэдрэмж сайжрах, орон зайн баримжаа хөгжих гэх мэт давуу талтай.

“ БАГА НАС БУЮУ 0-6 НАС НЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХАМГИЙН ЭРЧИМТЭЙ ЧУХАЛ ҮЕ ЮМ ”

ЦЭЦЭРЛЭГИЙН БҮХ НАСНЫ БҮХ АНГИД АШИГЛАХ БОЛОМЖТОЙ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН БАГЦ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН



13 СЭДЭВ

80 AR PUZZLE

400 АГУУЛГА


 3 хэмжээст хөдөлгөөнт дүрслэл

 Дүрс бичлэг

 Дуу авиа

 Өөрийгөө танилцуулж ярина

 Удирдаж явна

 Зан төлөвөө илэрхийлнэ

 Эвлүүлж тоглоно

 Сэтгэхүй хөгжүүлнэ

Энэхүү тоглоом нь тоглоход гарт эвтэйхэн, хурц өнцөггүй, хүүхдийн эрүүл, мэнд аюулгүй байдал, чанар, стандартын бүх шаадлагыг хангасан бөгөөд сургуулийн өмнөх насны боловсролын агуулгад дутагдалтай байдаг олон сэдвийг багтааж, илүү өргөн мэдлэгийн хүрээг хамарснаараа давуу талтай. Манай хамт олон цэцэрлэгийн багш нартай хамтран ажиллаж агуулгыг илүү баяжуулж, уг багцад багтах шинэ бүтээгдэхүүнийг тасралтгүй санал болгосоор байх болно.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛГА

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ



МОНГОЛ АХУЙ
СОЁЛ



НАРНЫ АЙМАГ



ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН
ЕРТӨНЦ



ДЭЛХИЙН ГАЗРЫН
ЗУРАГ



СОНИУЧ ПИПС



МИНИЙ МОНГОЛ
ОРОН



УРГАМАЛ



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД
АЮУЛГҮЙ ОРОЛЦОЁ



ЗЭРЛЭГ
АМЬТАД



ДАЛАЙН
АМЬТАД



ТЭЖЭЭВЭР
АМЬТАД



ТОО ТООЛОЛ



ӨНГӨ ДҮРС

ТОГЛОНГОО СУРАЛЦЬЯ

ӨНГӨ ДҮРС

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Амьдралд өргөн хэрэглэгддэг 14 дүрсийг нүдэлж, тэдгээрийн онцлог шинж чанар, хэлбэрийн ялгааг олж, бодит амьдрал дээр тухайн дүрсээр илэрдэг зүйлсийг нэрлэж сурахаас гадна өнгө ялгах чадварт сургана. Өнгө, дүрс тогтоох ийм л амархан шүү дээ. Бас адилтгаж, харьцуулж сурна.

3+ НАС 16 ХЭСГ
14-Н ШИРХЭГ
30x30cm

ТОО ТООЛОЛ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



1-10 хүртэлх тоонууд 3 хэмжээст дүрслэлээр гарч ирэн өөрийгөө танилцуулж, тоолж, монгол тооны бэлгэдэл, монгол ахуйн эд зүйлсийн тухай танилцуулна. Энэ тоглоомоор ганцхан удаа тоглоход л тоо тооллыг дахин хэзээ ч мартаггүйгээр сурна гээд бод доо.

3+ НАС 16 ХЭСЭГ
10-Н ШИРХЭГ
30x30cm

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД АЮУЛГҮЙ ОРОЛЦЪЁ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Хүүхэд багачуудыг болзошгүй аюулаас сэргийлэхэд хамгийн чухал шаардлагатай мэдлэг болох замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, зорчих дүрмийг таниулж, тэмдэг, тэмдэглэгээг тогтоолгож, яаралтай үед авах арга хэмжээ, хариу үйлдлийн талаар ерөнхий ойлголт өгнө. Хүүхдийн аюулгүй байдал чухал ч аюулаас урьдчилан сэргийлэхэд сургах нь түүнээс илүү чухал билээ.

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

МИНИЙ МОНГОЛ ОРОН

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Монгол орны үзэсгэлэнт байгаль, нуурууд, уул нурууд, түүхэн дурсгалт газруудын тухай өгүүлж, тухайн газар нутаг дахь ургамал, амьтдын онцлогийг таниулна. Эх орноо бүрэн мэддэг байх нь иргэн бүрийн үүрэг юм.

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

ДЭЛХИЙН ГАЗРЫН ЗУРАГ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Тив, далайн байршил, онцлог шинж чанар, Дэлхийн 7 гайхамшиг, тэдгээрийн тухай мэдээллийг ойн хөгжилтэй амьтдаар дамжуулан 3 хэмжээст байдлаар дүрслэн харуулж, газар зүйн талаар суурь мэдлэг олгоно. Ирээдүйн аялагчдад маань хамгийн хэрэгтэй мэдлэг биш гэж үү?

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

МОНГОЛ АХУЙ СОЁЛ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Монгол ахуй, нүүдэлчин соёл, таван хошуу малын нэршил, онцлог шинж чанар, Монгол гэрийн бүтэц, барих дараалал зэрэг олон талт мэдлэг мэдээллийг авч суралцах боломжтой. Монгол өв соёл, түүх, уламжлалаараа аялахаас гадна, хамтдаа монгол гэрээ барьж сурах нь ээ.

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

НАРНЫ АЙМАГ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Нар болоод түүнийг тойрон эргэх 8 гараг, тэдгээрийн дагуулууд, тэнхлэгээ эргэх хөдөлгөөн, гаргуудын шинж чанар болон хоорондын зайн талаарх олон талт мэдлэг мэдээллийг авч суралцах боломжтой. Төсөөллөө бодит болгож, сансар огторгуйгаар аялахад бэлэн үү?

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

БЯЦХАН АМЬД ЕРТӨНЦ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Байгаль дээрх бяцхан амьд ертөнц болох шавжнууд, тэдгээрийн харагдах байдал, онцлогуудын тухай таниулахаас гадна хүчил төрөгчийн эх үүсвэр болсон ногоон ургамлын аймгийн тухай өгүүлнэ. Бяцхан судлаачдын маань хамгийн дуртай сэдвүүдийн нэг шүү дээ.

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm

ТЭЖЭЭВЭР АМЬТАД

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Хүүхэд багачуудын маань дотны найзууд болох гэрийн тэжээвэр амьтад, зарим бэлчээрийн малыг нэрлэж, тэдний онцлог, хооллолт, зан чанар, дуу авиаг таниулж, хүүхдүүдэд амьтдыг хайрлах, асрах сэдлийг бий болгоно. Амьтдыг хайрлах энэрэнгүй сэтгэлийг хөгжүүлэхэд энэ тоглоом туслах болно.

3+ НАС 16 ХЭСЭГ
10-Н ШИРХЭГ
30x30cm

ЗЭРЛЭГ АМЬТАД

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ



Зэрлэг амьтдын нэр, харагдах байдал, онцлог шинж чанарыг 3 хэмжээст дүрслэл, аудио, видео контентоор дүрслэн харуулж, гайхамшигт амьтдын ертөнцийн тухай танин мэдэхүйн мэдлэг олгоно. Амьтанд дуртай хүүхдүүдийн хамгийн дуртай тоглоом байх болно гэдэгт итгэлтэй байна.

3+
НАС

16
ХЭСЭГ

10-Н ШИРХЭГ
30x30cm

ҮЛЭГ ГҮРВЭЛИЙН ЕРТӨНЦ

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Эртний эрин үед амьдарч байсан үлэг гүрвэлүүдийг хүүхдэд сонирхолтой байдлаар 3 хэмжээт дүрслэлээр харуулж, үлэг гүрвэлүүд өөрсдийгөө танилцуулж дуу авиа шинж чанараа илэрхийлнэ. Бяцхан шавь нартайгаа хамт үлэг гүрвэлийн гайхамшигт ертөцөөр аялаарай.

3+
НАС

16
ХЭСЭГ

10-Н ШИРХЭГ
30x30cm

ДАЛАЙН АМЬТАД

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Тэнгис далайн амьтад, тэдгээрийн онцлог шинж чанарын талаар ерөнхий ойлголтыг авахаас гадна далайн аквариумд зочилсон мэт мэдрэмжийг авч, харилцан ярилцаж, суралцах боломжтой. Паззлаа эвлүүлээд л далайн гүнд аялах боломжтой болно гэсэн үг шүү дээ. Гайхамшигтай байгаа биз?

3+
НАС

16
ХЭСЭГ

10-Н ШИРХЭГ
30x30cm

СОНИУЧ ПИПС

AR ТЕХНОЛОГИОР БАЯЖУУЛСАН 3D ИНТЕРАКТИВ ЭВЛҮҮЛДЭГ ТОГЛООМ

3+



Сониуч Пипс болон түүний найз Мембол нарын адал явдал, тэдний амьдардаг Гранео гарагийн тухай өгүүлнэ. Гайхамшигт Гранео гараг ямар харагддаг бол? Дэлхийгээс өөр болов уу? Паззлаа эвлүүлээд үзээрэй.

3+ НАС 88 ХЭСЭГ
НЭГ ШИРХЭГ
88x59cm



Технологид суурилсан тоглоомоор дамжуулан мэдлэг, боловсрол олгох дахин давтагдашгүй, цоо шинэ сургалтын хэрэглэгдэхүүнийг бүтээж, Та бүхэнтэй хамтран ажиллах болсондоо бид туйлын баяртай байна.

Эрхэм хүндэт багш нартаа технологийн эрин зууны ирээдүй болсон хүүхэд багачуудыг технологи, шинжлэх ухаан, мэдлэгт чиглүүлэх их үйлсэд нь амжилт хүсье .

ХОЛБОО БАРИХ:

✉ info@argun.mn

☎ 7733-4477

🌐 www.argun.mn



Энэхүү QR кодоор AR Mongolia аппликейшныг татаж камерыг тэмдэглэгээтэй хавтас руу чиглүүлж, сургалтын хэрэглэгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг виртуал менежерээс аваарай.